



*Empowered lives.  
Resilient nations.*

## “ХАРИУЦАГАТАЙ УУЛ УУРХАЙ” СЭДВЭЭР СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТАЙЛАН



2016 он 12 сар

## **ДУНДГОВЬ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН “ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ” СЭДЭВТ СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

### **НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

#### **Сургалтын зорилго**

Хариуцлагатай уул уурхай (ХУУ) сэдэвт сургалтын зорилго нь уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч болон сонирхогч талууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад хариуцлагатай уул уурхайн талаар зохих мэдлэгийг системтэй олгох, хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудыг олон нийтэд ойлгуулах, сургагч багш бэлтгэх, мөн энэ чиглэлээр гарах сургалтын аргачилсан гарын авлага боловсруулан гаргахад сургалтад оролцогчдоос санал авах зорилготой юм.

#### **Хэрэгцээ, шаардлага**

УИХ-ын 2014 онд батлагдсан “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ын 3.3.1-д “... байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах” гэж заасан байдаг.

Хариуцлагатай уул уурхай түүний зарчмуудын талаар иргэд болон үйлдвэрлэгчид тодорхой ойлголт байхгүй, түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах гарын авлага ч гараагүй байгаа юм. Иймд хариуцлагатай уул уурхайн тухай цогц ойлголтыг олон нийтэд идэвхтэй түгээх, танилцуулан ойлгуулах чиглэлээр орон нутгийн холбогдох хүмүүсийг сургах, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх аргачилсан гарын авлагыг бий болгох нэн шаардлагатай байна.

### **ХОЁР. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР**

Сургалтанд оролцогчдод зориулсан хариуцлагатай уул уурхайн сургалтын 11 модуль боловсруулсан. Эдгээр модулиар хичээл заах презентацийг тус тус бэлтгэсэн. Сургалтыг төвийн бүсийн нэг аймгийг сонгон авахаар төсөлд тусгасан байсан. Бид хэд хэдэн аймагт сургалт явуулахаар тухайлан Өмнөговь, Өвөрхангай аймаг зэргийг судлан үзсэн боловч эдгээр аймгуудад сургалт давхацсан байсан тул төлөвлөсөн хугацаанд эдгээр аймгуудад хийх боломжгүй болсон. Иймд бид Дундговь аймагт сургалт явуулахаар сонгон авлаа.

Тус аймагт ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 38, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 8 компани нүүрс, алт, төмөр, жонш, гөлтгөнө, цагаан мөнгөний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг юм байна. (мэдээллийг 1 дүгээр хавсралтаас харах)

Сургалтыг Дундговь аймгийн төв Мандалговьд 2016 оны 11-р сарын 28, 29-нд зохион байгууллаа.

Сургалт явуулахын өмнө бид Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэтэй холбогдож, сургалтын зорилгын талаар танилцуулсан. Мөн аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн А.Өлзийбалжир, аймгийн захиргаа аж ахуйн ахлах мэргэжилтэн Л.Цэвээнравдан нартай хамтран ажиллаж, сургалтыг зохион байгууллаа.

Суралцагсдын бүрэлдэхүүнд төр, үйлдвэрлэгч, ТББ байгууллагын төлөөлөл хамрагдсан байхаар төлөвлөсөн бөгөөд орон нутгийн нөхцөл байдлаас хамаарч аймгийн төвөөс 3 хүн, орон нутгаас 18 хүн нийт 21 хүн сургалтад оролцсон бөгөөд үүнд аймгийн ЗДТГ, МХГ, БОАЖГ-аас тус бүр нэг хүн, Сайнцагаан сумаас-1, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Дэлгэрхангай, Говь-Угтаал сумаас тус бүр 3, Луус сумаас 2 хүн, Улаанбаатараас 3 хүн нийт 24 хүн оролцов.

Оролцогчдод төрийн албан хаагч 12, компанийг төлөөлж 6, ТББ-г төлөөлж 6 хүн байснаас 10 эмэгтэй, 14 эрэгтэй хүн байлаа. Түүнчлэн Улаанбаатар хотоос “Хил хязгааргүй алхам” ТББ-н тэргүүн Н.Баярсайхан, Эко сфера ХХК-н менежер, гидрогеологич А.Наранбат, АЖЭД ХХК-н менежер, нефтийн инженер Г.Амарбаяр нар оролцсон болно. Оролцогчдын нэр, ажил, утасны дугаарыг **2 дугаар хавсралтад** үзүүлэв

Сургалтыг Дундговийн Засаг даргын Тамгын газрын хурлын байранд зохион байгуулсан. Сургалтыг нээж Дундговь аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн А.Өлзийбалжир, Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын тэргүүн Л. Долормаа нар үг хэлсэн. Сургалт хөтөлбөрийн дагуу явагдав.

### Сургалтын хөтөлбөр:

Цаг	Сургалтын сэдэв	Илтгэгч, чиглүүлэгч
<b>Сургалтын I өдөр: Нээлт, 1-6 дугаар модуль</b>		
09.00-09.30	Оролцогчдын бүртгэл	Г.Амарбаяр
	Сургалтын нээлт: - Дундговь аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн ТХХУУС ТББ-ын Тэргүүн	А.Өлзийбалжир ТХХУУС ТББ-ын Л.Долормаа
9.30 -10.00	Оролцогчдын танилцуулга	Г.Батсайхан
	Сургалтын зорилго, хөтөлбөр, үр дүнг танилцуулах, баримтлах дүрмээ хамтран тодорхойлох	ТХХУУС-ын Гүйцэтгэх захирал
10.00-11.00	Сургалт: Модуль 1. Уул уурхайн тухай ерөнхий ойлголт	Г.Батсайхан
12.00-11.15	Цайны завсарлага	Г.Батсайхан
11.15-12.45	Уурхайн ашиглалт	Л.Долормаа
12.45-13.00	Уурхайн БОНБХУ талаар	Л.Долормаа
13.00-14.00	Үдийн хоол	
14.00-14.30	Уул уурхайн нөхөн сэргээлт	Л.Долормаа

14.30-14.45	Уул уурхайн хаалтын үйл ажиллагаа	Л.Долгормаа
14.45-15.20	Модуль 3. Олон талын оролцоог хангах тухай	Г.Батсайхан
15.20-15.40	Бүлгийн ажил. Өөрийн уурхайд олон талын оролцоог хангаж байгаа байдалд дү шинжилгээ хийх.	Г.Батсайхан
15.40-16.00	Цайны завсарлага	
16.00-16.45	Модуль 4. Ил тод, нээлттэй байх тухай	Г. Батсайхан
16.45-17.00	Бүлгийн ажил. Ил тод байх мэдээлэл	Г. Батсайхан
17.00-17.35	Модуль 5. Хуулийг сахин дээдлэх тухай	Г.Батсайхан
17.35-17.50	Бүлгийн ажил. Амьдрал дээр хуулийн хэрэгжилтийн жишээ	Г.Батсайхан
17.50-18.00	Өдрийн сургалтын үр дүнгээр ярилцах	Л.Долгормаа, Г.Батсайхан
<b>Сургалтын II дахь өдөр:</b>		
09.00-09.10	Өмнөх өдрийн сургалтын тойм	Г.Батсайхан, Л.Долгормаа
09.10-10.20	Модуль 6. Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх тухай	Л.Долгормаа
10.20-10.35	Бүлгийн ажил. Уул уурхайгаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Л.Долгормаа
10.35-11.25	Модуль 7. Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах тухай	Г.Батсайхан
11.25-11.40	Цайны завсарлага	
11.40-12.00	Бүлгийн ажил Уул уурхайгаас хандив тусламж яаж өгөгддөг тухай	Г.Батсайхан
12.00-12.45	Модуль 8. Үр өгөөжтэй байх тухай	Л.Долгормаа
12.45-13.00	Бүлгийн ажил. Аймгийн уурхайнуудын төлдөг татвар	Л.Долгормаа
13.00-14.00	Үдийн хоол	
14.00-14.45	Модуль 9. Хүмүүнлэг ёс зүйтэй байх тухай	Л.Долгормаа
14.45-15.00	Бүлгийн ажил. Хүмүүнлэг ёс зүй	Л.Долгормаа
15.00-15.45	Модуль 10. Дэвшилтэт технологид суурилсан байх тухай	Г.Батсайхан
15.45-16.00	Цайны завсарлага	
16.00-16.45	Модуль 11. ХУУ-г хөгжүүлэхэд төрийн албадын чиг үүрэг	Г.Батсайхан
16.45-17.00	Бүлгийн ажил. Шалгах шалгуур үзүүлэлт	Г.Батсайхан
17.00-17.50	Сургалтын дүгнэлт ярилцлага	Л.Долгормаа, Г.Батсайхан
17.50-18.00	Хаалт:	

Сургалтад оролцогч тус бүрд хичээлийн бүх сэдвээр презентаци, дэвтэр, бал, хавтас зэргийг бэлдэж тарааж өгсөн. Хичээлийн сэдвээр хийсэн презентациудыг файлаар хавсаргав. Түүнчлэн хичээлд хариуцлагатай уул уурхайн голлох зарчмыг

нарийвчлан заах чиглэлийг баримталсан бөгөөд асуулт хариултыг чөлөөтэй байлгаж, харилцан ярилцах хэлбэрээр явуулсан.

Сургалтаар дараах мэдлэгийг олгосон. Үүнд:

- Уул уурхайн талаарх ерөнхий ойлголт. Үүнийг уул уурхайн ажлын үе шат болох геологи хайгуул, уурхай байгуулах, ашиглах, хаах гэсэн 4 бүлэгт хуваан заагаад, байнга хэрэглэгдэх мэргэжлийн ухагдахуун болох байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээлт, химийн бодисын хэрэглээ, аюултай хог хаягдлын талаарх ойлголтыг арай дэлгэрэнгүй хэмжээнд заав.
- Хариуцлагатай уул уурхайн ойлголт түүний зарчмуудыг хэрэгжүүлэх аргачилал
- Монголд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд төрийн албадын үүрэг, оролцоо.

Бүлгийн ажлыг заасан хичээлээ бататгах, түүнийг амьдралтай холбон ярилцах, даалгавар өгч гүйцэтгүүлэх хэлбэрээр суралцагсдад хариуцлагатай уул уурхайн талаар суралцсан хичээлийн ойлголтыг нь гүнзгийрүүлэх зорилгоор хийлээ. Үүнийг оролцогчид харилцан ойлголцлыг бий болгох, санал солилцон хамтран ажиллах чухал ач холбогдолтой боллоо гэж дүгнэсэн. Үүгээр суралцагсад үзсэн хичээлийг бататгахаас гадна сургалтын модуль, ХУУ-н зарчмын шалгуур үзүүлэлтийг хэрхэн баяжуулах талаарх санаа бодлыг нь сонсох ажил бас хийгдэв. Бүлгийн ажлын зааврыг **3 дугаар хавсралтад** үзүүлэв

## **ГУРАВ. СУРГАЛТАД ОРОЛЦОГЧДЫН МЭДЛЭГ, ЗААХ АРГЫН УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ**

Сургалтын үнэлгээг өдөр тутам сургалтын дараа оролцогчдоос сургалтын хэрэгцээ шаардлага, ач холбогдол, сургагч багш нарын ур чадвар, оролцогчдын сэтгэл ханамж, цаашид анхаарах зүйлийн талаар бичгээр нэргүйгээр авч байв. Санал асуулгын хуудсыг **4 дүгээр хавсралтаар** үзүүлэв.

Сургалтын үнэлгээний дүнг тоймловол:

- Давхардсан тоогоор 26 оролцогч сургалтын үнэлгээний хуудсыг бөглөсөн байна;
- Оролцогчдын 85% нь сургалтаас хүлээж байсан мэдлэг, чадвараа олж авсан гэж үзсэн;
- Сургалтын ерөнхий зохион байгуулалтыг 92 хувь нь хангалттай гэж үнэлсэн;
- Багш нарын ур чадварыг 88.2% нь мөн хангалттай гэж дүгнэсэн байна.

Энэхүү сургалтаас танд хамгийн таалагдсан 3 зүйлийг бичнэ үү? гэсэн асуултанд дараах байдлаар хариусан байна. Үүнд:

1. Сургалтын агуулга, сэдвүүд, илтгэл тавьсан байдал нь бидний мэдлэгийг гүнзгийрүүлж чадсан гээд нилээд олон сэдвийг онцлон дурдсан байна.

2. Сургалтын зохион байгуулалт, гарын авлага, сургалтын орчин таалагдсан тухай бичсэн байна.

3. Бүлгийн ажил, онолыг практиктай холбож хичээлээ тайлбарласан байдал, ХУУ-н талаар системтэй сургалтын модуль боловсруулж өгч, энэ талаар биднийг цэгцтэй мэдлэгтэй болгосонд талархсан байна

Цаашид сургалт зохион байгуулахад анхаарах, илүү сайжруулах зүйлийн талаар танд ямар санал хүсэлт байна вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна.

1. Сургалтыг илүү өргөн хүрээг хамруулж далайцтай, төрийн байгууллагуудыг татан оролцуулж явуулж байх, цахимаар сургалт хэлэлцүүлэг хийж байх, сургалтыг давтан явуулж байх тухай
2. Сургалтын гарын авлагаа арай томруулж хэвлэх, урьдчилан тарааж байх
3. Лекцэнд эх сурвалжаа бичих, сэдэвтэй холбоотой жишээ баримтыг илүү оруулж өгөх, сургалтын явцад асуусан асуултын хуулийн заалтыг хэлж тусалдаг байх тухай
4. Бүлгийн ажлын дүгнэлтийг сайжруулж, сургалтанд хамрагдагсдын үр дүн, хэрэгжилтэнд тандалт хийж байх тухай хэлсэн байна.

#### Сургалтын гарын авлагыг сайжруулах талаар:

Оролцогчид дараах зүйлийг гарын авлагад оруулах нь зүйтэй гэсэн санал гаргасан. Үүнд:

1. Хуулиар хориглоогүй мэдээлэл гэдгийг модуль дотроо тодорхойлон хэлсэн байх

2. Гадаад, дотоод ажилчдын тоо, авч байгаа цалингийн харьцуулсан үзүүлэлт, гадаад ажилчдын визний байдал, монгол хүнийг ажиллуулахгүй НД-г нь төлдөг эсэх, ажлын болон илүү цагийн хэмжээ, гарч буй ажлын байр, шаардлагатай хүний нөөц, худалдан авах бараа бүтээгдэхүүний жагсаалт, хэрэглэж буй химийн бодисын нэр, хэмжээ, түүнийг хоргүйжүүлсэн мэдээлэл, ус ашиглах төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг зүйлсийг ил тод байхаар модульд оруулахыг хүслээ

3. Бичил уурхай, түгээмэл тархацтай ашигт малтмал энд хамаарах эсэх, нутгийн захиргааны байгууллага хяналт тавина гэж хуульд заасан нь тэд юу хийхийг хэлээд байгаа тухай, 4тонн жоншийг шинжилж туршина гээд үнэгүй аваад явдаг нь ямар хуулиар зохицуулагддаг талаар асуусан байна.

4. Модульдаа геофизикийн хайгуул, далд уурхайн хаалт, дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх, хаалтын нөхөн сэргээлтийн олон улсын туршлагууд, далд уурхайг ашиглах технологи, цианид, хүхрийн хүчил юунд, яаж хэрэглэдэг талаар мэдээлэл оруулж өгөхийг хүссэн байна



Хичээлийн төгсгөлийн ярилцлагын үед гарсан санал

1. Сургалтын гарын авлагыг олноор хэвлээд орон нутгаар тараах хэрэгтэй байна, зарна гэвэл хүмүүс худалдаж авдаггүй юм шүү
2. Сургалтыг хөдөө сумдаар хиймээр байна.
3. Үйлдвэрлэгчдийн яриаг тоймлон бичихэд:
  - Уул уурхайн компани энд бичсэн зүйлийг хэрэгжүүлэх боломжтой юм байна. Гэхдээ манай дарга нар, дамаангүй манай Хятад эзэн хийдэггүй. Одоо жишээ нь нэг айлыг нүүлгэн шилжүүлэх хэрэгтэй байдаг. Тэр айл 20 сая төгрөг нэхээд хөдөлдөггүй. Гэтэл компаниас тэр мөнгийг өгөхгүй гэсэн. Одоо тэр айл уурхайн талбайд, тоос шороонд дарагдаад байж байгаа. Тиймд дарга нарт ойлгуулах, тэдэнд энэ ажлыг хийх ёстой гэсэн хөшүүрэг хийж өгмөөр байна
  - Орон нутгийн зөвлөл байгуулна гэдэг чинь их зөв байна. Түүнийг очоод би шууд хэрэгжүүлэх бодолтой байна
4. Улсын байцаагчид:
  - Төрийн албадын үүрэгт шалгах ажлын жагсаалт ойлгомжтойгоор гарсан байна. Энэ ажлыг бид шалгаад, шаардлагаа тавиад явж болж байна. Гэтэл энэ шалгуур албажсан, эрх зүйн баримт болсон байх шаардлагатай.
  - Тэр стандарт болгоно гэдэг чинь зөв байна. Тэгэхгүй бол бид энэ дагуу шалгах, ХУУ-н зарчмуудыг хэрэгжүүлүүлэх эрхгүй байна. Учир нь бидний үүрэг бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулахад оршдог.
  - Хяналт мэдээллийн ихэнх ажлыг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар гүйцэтгэх юм байна. Одоогоор Монгол улсын бүх сумдад байгаль орчны хяналтын улсын байцаагч ажилладаг. Гэхдээ энд хяналт, мэдээлэл цуглуулахад зөвхөн манайхаас гадна аймгийн татварын, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, нийгмийн бодлогын гэх мэт албадуудын оролцоо байх юм байна шүү.
  - Манай улсын байцаагч нар хяналт шалгалт хийхэд 4 чиглэлийг баримталдаг. Түүнээс гадуур, өөр зүйлээр шалгалт хийхийг хориглох болсон. Шалгалт хийхдээ шалгах зүйлсийн жагсаалтыг батлаад өгсөн хяналтын хуудсууд байдаг. Эдгээр хяналтын хуудас МХЕГ-н вэб сайтад байгаа. Тиймд ХУУ-г хэрэгжүүлэх нөхцөлд энэ нь стандарт болж батлагдахгүй бол бид хэрэгжүүлүүлэхээр шахаж шаардах боломжгүй юм
  - Бид аймгийнхаа уурхайнуудад хариуцлагын төвшин тогтоож үзээд, тэд сайн эсвэл муу байгааг бодитойгоор тогтоогоод, цаашид шаардлагаа тавиад ажиллах боломж эндээс харагдаж байна. Гэтэл үүнийг хийх, хийж болох удирдамж, зөвлөмж хотоос, дээд газраас ирэхгүй бол бид дураараа юм хийсэн болох гээд байна. Биднийг дураараа юм шалгаад эхлэхээр авилгал, нэр төр гээд асуудлууд үүсээд ирдэг

- А.Өлзийбалжир ярилцагсдад мэдээлэл өгөх зорилгоор Дундговь аймагт ажилладаг уурхайн тоо, тэдгээрийн төлсөн татвар, өгсөн хандивын хэмжээг хүснэгтээр үзүүлснийг тайланд хавсаргав.

5. ТББ-н төлөөлөл:

- Бид сайхан мэдээлэл сонслоо. Тодорхой хэмжээнд боловсорлоо. Баярлалаа.

**Сургалтын ач холбогдол үр дүн:**

- Хариуцлагатай уул уурхай, уул уурхайн ямар үйл ажиллагааг хариуцлагатай гэх гэдэг талаар нарийвчилсан ойлголтыг орон нутгийн хүмүүст зааж сургаснаар эдгээр хүмүүс нь уул уурхайг хариуцлагатай явуулах чиглэлээр онол, практик хосолсон мэдлэгтэй болж, бусдад зааж сургах чадвартай болсон гэж дүгнэж байна.
- Эдгээр багш нар орон нутагт хариуцлагатай уул уурхай, тэдгээрийн зарчим, дүгнэх үзүүлэлтийн талаар зааж сургаснаар уурхай эрхлэгчдээс гадна төрийн болон төрийн бус байгууллага орон нутгийн иргэд уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих мэдлэгтэй болно.
- Уул уурхайг хариуцлагатай болгосноор тэдгээрийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсч болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэндэд учрах аюул, осолоос урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэхээс гадна баялгийн хуваарилалт зохистой явагдах, оршин суугчдын амьдрал ахуй дээшлэх, ажилгүйдэл ядуурал буурах, хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах нөхцөл бүрдэнэ.

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Сургалтын үед хийгдсэн бүлгийн ажлын үр дүн, чөлөөт ярилцлага, нэргүй судалгааны материалыг бүлэглэн нэгтгэж, судалснаар мөн тэдгээрийг судалж байх үед нэмж төрсөн санаануудыг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна:

1. *Сургалтын гарын авлагыг сайжруулах талаар.* Сургалтын гарын авлагад байгаа материалаас хасахаар илүүдсэн агуулга байхгүй, харин дараах мэдээлэл, ойлголт нэмж оруулахыг суралцагсад хүсч байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна.

а. Уул уурхайн ерөнхий ойлголтод геофизикийн хайгуул, химийн бодисын хэрэглээ гэх мэт саналын хуудсанд бичсэн ойлголтуудыг оруулж өгөхийг хүссэн байна. Эдгээр нь мэргэжлийн бус хүмүүсийн мэдэх шаардлагатай мэдээлэл байсан тул энэ саналыг хүлээн авах нь зөв гэж үзсэн

б. Хариуцлагатай уул уурхай түүний 8 зарчмын талаар бичсэн 2-10 дугаар модульд зарим шалгуур үзүүлэлтэд нэмэлт зүйл оруулах санал гаргажээ. Энэ нь амьдрал дээрээс урган гарсан ихэнх нь авууштай саналууд байсан тул гарын авлагад оруулах нь зөв гэж үзсэн.



2. *Сургалтын хөтөлбөрийн талаар.* Сургалт явуулж байх явцдаа лекцийн хичээлийн бодит үргэлжлэх хугацааг тогтоосон тул сургалтын хөтөлбөртөө цаг хугацааны хувьд өөрчлөлт оруулж, Хариуцлагатай уул уурхай сургалтын жишиг хураангуй болон дэлгэрэнгүй хөтөлбөрийг шинэчлэн гаргаж **5 дугаар хавсралтад** оруулав.

3. *Сургалтыг зохион байгуулах талаар.* Сургалтыг зохион байгуулалт, хичээл заалт хүмүүсийн ярилцлага, хяналтын хуудсанд бичсэн зүйлсээс харахад сайн хийгдсэн гэж дүгнэгдсэн байна. Ийм маягаар сургалтыг цаашид явуулах боломжтой гэж үзлээ. Сургалтыг сумд түүний уурхай дээр холбогдох бүх талыг нь байлцуулж байгаад хийвэл газар дээрээ, амьдрал дээр нь халуун яриа өрнүүлсэн, бодитой, илүү үр дүнтэй сургалтууд болох юм байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

4. *Хариуцлагатай уул уурхайг Монголд хөгжүүлэх талаар.* Монголд Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд дараах шат дараатай арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна:

- *Хариуцлагатай уул уурхайн гарын авлагыг бий болгох.* Гарын авлага мэргэжлийн бус хүмүүс уншиж, ойлгоход хялбар, тод томруун зураг, амьдралд тохиолдсон жишээнүүдээр баяжуулсан, уул уурхай эрхлэгчид гарын авлагыг ашиглаж байгууллага дээрээ ХУУ-г хөгжүүлэх боломжтой, аргачилсан хэлбэртэй байх шаардлагатай.
- *Монголд үйл ажиллагаа эрхэлж буй уурхайнуудын хариуцлагын төвшинг тодорхойлж нийтэд зарлах.* Үүнийг улс даяар тодорхойлохоос гадна аймаг бүр өөртэй тодорхойлох зөвлөмж, аргачиллыг төрийн захиргааны байгууллагаас орон нутагт өгөх.
- *Сургалтыг орон даяар явуулах.* Үүний тулд сургагч багш нарыг бэлтгэнэ, сургалт тасралтгүй явагддаг системийг бий болгоно. Мөн сургалтын онлайн, теле хичээлүүдийг бэлтгэн орон нутагт хүргүүлэх шаардлагатай болно.
- *Хариуцлагатай уул уурхайн хэрэгжилтэд төрөөс хяналт тавих эрх зүйн үндсийг бий болгох.* Үүнийг хийхийн тулд нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг шаардлагатай. ХУУ-н хувьд хариуцлагатай уул уурхайн стандарт гарч байж, Мэргэжлийн хяналтын газраас түүнд хяналт тавих эрх үүсэх юм байна. Иймд ХУУ-н стандартыг гаргах шаардлагатай.



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ  
УУЛ УУРХАЙН САНААЧИЛГА ТББ**